

БАТЛАВ:

СУМ ДУНДЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ХУУЛЬ ЦААЗЫН  
ИТГЭМЖИТ ЗӨВЛӨХ Б.ЭРХЭМБААТАР

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН  
ПРОКУРОРЫН ГАЗАР**

Огноо: 2020 оны 03 дугаар сар 12

**КОНТОРЫН БАРИЛГЫН ДЭЭВЭР ЗАСВАРЫН АЖИЛ  
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГУУЛАХ ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ**

**Тендер шалгуулалт: Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын  
прокурорын газрын барилгын дээвэр засварын ажил  
гүйцэтгэгчийг сонгон шалгуулах**

**Гэрээний дугаар: ХА-2020/01**

Нэг. **ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

Огноо: 2020.03.12

**Манадал сум дахь сум дундын прокурорын газар** эрх бүхий тендерт оролцогчдоос “Сум дундын прокурорын газрын барилгын дээвэр засварын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах” үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 03 дугаар сарын 20-ний 11.00 цагаас өмнө tender.gov.mn цахим хуудсаар ирүүлнэ.

Үнийн саналын нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн 11.30 цагт нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй  
Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**[Монгол улс, Сэлэнгэ аймаг, Мандал сум, 3-р баг, Сум дундын Прокурорын газрын  
I давхарт нягтлан бодогчийн өрөө, нягтлан бодогч Э.Эрдэнэчимэг, утас  
99686318]**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч
  - 1.1 Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт / цаашид “ТШӨХ” гэх /-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
  - 2.1 Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2 Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
  - 3.1 Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлсээс бүрдэнэ.
    - (а) Үнийн санал
    - (б) Оролцогч компанийн танилцуулга
    - (в) Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг
    - (д) Ижил төрлийн ажил, үйлчилгээ үзүүлсэн туршлага гэрээ холбогдох тайлангийн хуулбар
    - (е) Тусгай зөвшөөрлийн баталгаажсан хуулбар
    - (ё) Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбарТендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл  
Харьяалагдах банкны тодорхойлолт /өргүй байх/ эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх  
Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх  
Гэрээг гүйцэтгэгч удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл
4. Тендерийн Үнэ
  - 4.1 Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2 Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3 Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын

хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг гнр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

- 4.4 Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
- 5.1 Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Алдааг залруулах
- 6.1 Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна.
- (а) Тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ.
  - (б) Үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна.
  - (в) Нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2 Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1 Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2 Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

8.1 Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээний заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: БХБСайдын Барилга угсралтын ажлын 2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт /БА-8.1/ ажилбарын заалт бүхий хүчинтэй хугацаа дуусаагүй, барилгын зөвшөөрөлтэй байна.</li> <li>2. Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх - Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар / гэрээ болон хавсралтын хамт / - Оролцогч компанийн танилцуулга</li> <li>3. Ажил гүйцэтгэгч нарийвчилсан хугацааны график гарган баталгаажуулж ирүүлнэ.</li> <li>4. Тусгай зөвшөөрлийн баталгаажсан хуулбар /гэрээ болон хавсралтын хамт хүчинтэй/</li> <li>5. Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график гарган баталгаажуулж ирүүлнэ.</li> <li>6. Тусгай зөвшөөрлийн баталгаажсан хуулбар /гэрээ болон хавсралтын хамт хүчинтэй/</li> <li>7. Харьяалагдах банкны тодорхойлолт /өргүй байх/ эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /тооцоогүй байх/ эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</li> <li>8. Гэрээг гүйцэтгэгч удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл Хариуцсан инженер 1 жилээс доошгүй жил тухайн компанид ажилласан байх бөгөөд нийгмийн даатгалын сүүлийн 6 сарын НД-8 маягтыг ирүүлэх</li> <li>9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан инженертэй байх /гэрээт бол гэрээг хавсаргах/ Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизм, багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлтэй байх</li> <li>10. 2019 оны санхүүгийн тайлан</li> <li>11. Борлуулалтын орлого: Сүүлийн нэг жилийн борлуулалтын орлого</li> </ol>

	<p>22 000 000 төгрөгөөс доошгүй байх</p> <p>12. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн нөхцлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, гаргацтай байх шаардлагатай.</p> <p>ТШӨХ-д шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Энэхүү ажлын шалгаруулалтын нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</li> <li>- Огноо: 2020 оны 03 дугаар сарын 20-ний өдөр</li> <li>- Цаг: 11 цаг 00 минут</li> </ul>
ТҮӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын хаяг – Сэлэнгэ аймаг, Мандал сум, 3-р баг, Сум дундын Прокурорын газар</li> <li>- Давхар болон өрөөний дугаар – 2 давхар, Ерөнхий прокурорын өрөө</li> <li>- Огноо: 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр</li> <li>- Цаг: 11 цаг 30 минут</li> </ul>
ТҮӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ. Нэг багцтай</p>

### Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Мандал сум дах сум дундын прокурорын газрын конторын барилгын дээвэр болон дотор заслын засварын ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг хавсаргав.

## ЦАЛИНГИЙН НЭГТГЭЛ

## ЗАСВАРААР ХИЙХ АЖИЛ

Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Дундаж хөдөлмөрийн зарцуулалт/ үндсэн ажил/ тэт ачиж бүүлгах/				
				Дундаж зэрэг	Нэгж хүн цаг	Бүгд хүн цаг	Нэгж цалин	Бүгд цалин
12-150-04	Модон сараалжтай долгионнт төмөр дээвэр хийх Тамбур орсон	м2	210	2.6/20	0.733/ 0.058	70.368/ 5.568	12,000.00	2,520,000.00
35-180-06	Төмөр дээвэр бүүлгах модон сараалж бүүлгах засварлах	м2	210	2.5/2.0	1462/0.2	6082/2.2	5,250.00	1,102,500.00
<b>НИЙТ</b>								<b>3,622,500.00</b>

## МАТЕРИАЛ ТЭЭВРИЙН ЗАРДАЛ

Шифр	Материалын нэр	Материал				Тээвэр					НИЙТ МАТЕРИАЛЫН ЗАРДАЛ
		Хэмжих нэгж	Үнэ	НИЙТ орц	Зардал	Нийт жин	Зай	Зэрэг	Тариф	Зардал	
3-5114	Сэлгэж риветка /уртасгалч/	ш	8500	10	85000	0.9	176	2	308	25245.5	114,145.00
1-0094	Хадаас 125 мм	кг	5500	40	220000	0.4	176	2	388	13657.5	233,657.60
1-0095	Хадаас 70-110	кг	5500	40	220000	0.5	176	2	388	17072.0	257,072.00
1-0094	Хадаас 40-60 мм	кг	4400	20	88000	0.02	176	2	388	682.9	88,682.88
1-0811	Хар цавс	м2	8500	250	2125000	0.24	176	2	388	8194.6	2,132,194.56
1-4335	Хөөвө мод	м2	300000	6	1800000	0.06	176	2	388	2048.6	1,802,048.64
1-0051	Хар тос	кг	4500	30	135000	0.3	176	2	388	10243.2	145,243.20
1-0526	Цайрдсан төмөр утас	кг	5500	5	27500	0.05	176	2	388	2048.6	29,548.64
1-4522	Шахдаг хөвс	ш	10000	10	100000	0.06	176	2	388	2048.6	102,048.64
1-0095	Дээврийн цайрдсан хадаас	кг	9500	15	142500	0.02	176	2	388	682.9	143,182.88
2-1156	Кронштейн	ш	10000	25	250000	0.3	176	2	388	10243.2	260,243.20
1-5251	Дээврийн нурууны төмөр орой	ш	9500	15	142500	0.1	176	2	388	3414.4	145,914.40
1-3994	Захиалсан банз /Шувуун нурууны засварт/	м3	300000	11	3300000	1	176	2	388	3414.4	3,394,144.00
1-4158	Дам нуруу	м3	420000	8	3360000	1	176	2	388	3414.4	3,394,144.00
1-5250	Дээврийн долгионт төмөр	м2	15500	290	3875000	3	176	2	388	102432.0	3,977,492.00
1-43233	Бүүлгалтаас гарсан хог	м3	7500	3	22500	0.2	176	2	388	6828.8	25,378.80
1-0862	Эрэгтэй хадаас /3.5*35мм/	кг	3800	10	38000	0.08	176	2	388	2731.5	40,731.52
2-2819	Хуванцар ирээлэй Ф100 / ус залуулах/	м	15600	70	1092000	0.08	176	2	388	2731.5	1,094,731.52
2-2673	Холбох муфат	ш	3200	14	44800	0.008	176	2	388	273.2	45,073.15
1-1344	Хөнгөн цагаан төмөр эдлэл	кг	12500	60	750000	0.08	176	2	388	2731.5	752,731.52
1-0060	Даравч	кг	25000	2	50000	0.07	176	2	388	2390.1	52,390.08
1-4825	Дээврийн модон кавлга	м2	125000	1	125000	0.07	176	2	388	2390.1	127,390.08
1-0218	Тосон будаг	кг	12000	15	180000	0.1	176	2	388	3414.4	183,414.40
Нийт											18,466,405



НИЙТ ШААРДАГДАХ МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

ЗАСВАРААР ХИЙХ АЖИЛ

Шифр	Машин механизмын нэр	Нийт хэрэглээ	Нэгж үнэ	Бүгд цалин
11004	Цахилгаан өрөм	3	85000	255,000.00
11005	Хүрэ	5	9500	47,500.00
11001	Ажлын бээлий хамгаалах хэрэгсэл	20	3500	70,000.00
11006	Цахилгаан хөрөө	3	9500	28,500.00
11002	Шүүр	8	8500	68,000.00
11007	Бусад ажлын багж хэрэгсэл	15	9000	135,000.00
11008	Багс	8	2500	21,476.00
11009	Өнхрүүш/ иштэй/	5	6500	32,500.00
11003	Алх, сүх, лоом	15	12000	180,000.00
<b>Нийт</b>				<b>837,976.00</b>

## Тав. ЗУРАГ

### Зургийг санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

## Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

### Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож, үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх;

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэхийн төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, усхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Дотор заслын ажлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

### Ажил – өдрийн хуваарь

Ажил – өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил – өдрийн хуваарь ихэвчлэн дараах зүйлсээс бүрдэнэ.

(а) тендерт оролцогч ажил - өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт мөн ажил өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил – өдрийн нэр төрийн тоо хэмжээ, тендерт оролцогч ийн ажил – өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

### Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр /ихэвчлэн төслийн менежерийн / хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. **ТЕНДЕРИЙН МАЯГТ**

**[огноо]**

**(Захиалагч байгууллагын нэр)**-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, **[тендерт оролцогчийн нэрийг оруул]**, энэхүү тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн **[бараа болон бусад үйлчилгээний нэрийг оруул]**-г **[тендерийн үнийг тоогоор болон үсгээр оруул]** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэхээр санал болгож байна.
2. Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээнд заасан барааг гэрээ байгуулснаас хойш **[моо]** хоногийн дотор нийлүүлнэ. Энэ нь техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарьт үндэслэнэ.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс **[моо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
5. Бид, энэхүү тендер шалгаруулалтаар нийлүүлэгдэх бараа, түүнийг дагалдах бусад үйлчилгээний техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх

үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон үнэлгээний хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй болохоо мэдэгдэж байна.

6. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий этгээдийн гарын үсэг,

тамга: Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.   |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b><br>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |

- |   |  |
|---|--|
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>          | <p>9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.</p> <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.</p> |
| <b>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b> | <p>10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.</p>   |

#### **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- |   |   |
|---|---|
| <b>11. Үе шатны ажлын хуваарь</b>           | <p>11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.</p> <p>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.</p> |
| <b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</b> | <p>12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.</p>  |
| <b>13. Алданги</b>                          | <p>13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.</p>                                  |

#### **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- |                          |   |
|--------------------------|---|
| <b>14. Ажил дуусгах</b>  | <p>14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.</p> |
| <b>15. Хүлээж авах</b>   | <p>15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.</p>   |
| <b>16. Эцсийн тооцоо</b> | <p>16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.</p>   |

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ

## үед хийх төлбөр

мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2 Гэрээг захиалагчийн шаардлагаар эсвэл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан амтериалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбоотой зардал түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

## 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх

20.1 Гэнэтийн болон давтагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалагаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Мандал сум дах сум дундын Прокурорын газрын барилгын дээвэр засварын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ХА-2020/01
ГЕН 2.1	Ажил нь Мандал сум дах сум дундын Прокурорын газрын барилгын дээвэр засварын ажлаас бүрдэнэ. Ажлын талбайн нь (байршил)-д байрших ба зураг № ...-д зааснаар тодорхойлогдсон болно .
ГЕН 3.1	Төслийн менежер нь [томилогдсон этгээдийн нэр, хаяг]
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр[огноо] Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр [огноо]
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 24 сар байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0.05 хувь байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 50 хувиас ихгүй байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [огноо]-ны дотор гаргаж өгнө.

- 3 Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.
- 4 Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төсөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.
- 5 ажлын хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.





	Гүйцэтгэлийн зургийг [огноо]-ны дотор гаргаж өгнө.
	Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [мөнгөн дүн] байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 100 хувь-иар тооцно.

**ГЭРЭЭНИЙ МАЯГТ**

**ЗАХИАЛАГЧ**

**ГҮЙЦЭТГЭГЧ**

_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид "гүйцэтгэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид "ажил" гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/  
Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай,

\_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана,  
\_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга  
угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_  
инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/  
\_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар  
сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]